

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
03 ДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2018.02.26-2018.03.25/

2018 оны 03 дугаар
сарын 26-ны өдөр

Даланзадгад сум

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

1.1. Виз олголтын талаар:

Тайлант хугацаанд Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-ын дагуу хилийн боомтод виз олгоход шаардлагатай бичиг баримтыг биедээ авч явсан нийт БНХАУ-ын 3 иргэнд зохих ангиллын визийг олгож төлбөрийг төрийн санд төвлөрүүлэн ажилласан.

Үүнд:

- Визийн шилжүүлэг-3

Нийт 3 гадаадын иргэнд виз олгож, визийн хуудасны үнэ болох 21.647 төгрөгийг Гадаадын иргэн, харьяатын газрын Голомт банкны 1320000114 тоот дансанд, тэмдэгтийн хураамжийн 96.000 төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын 100110000941 тоот дансанд тус тус тушаалган ажилласан болно.

Тайлант хугацаанд Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор зорчсон БНХАУ-ын 2122 иргэний баримт бичиг болон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

Орох чиглэлд:1229

Гарах чиглэлд:893

1.2. Түр ирэгчийн бүртгэл, хасалт, оршин суух зөвшөөрлийн хасалт:

Тайлант хугацаанд БНХАУ-ын 74 иргэнд түр ирэгчийн бүртгэл хийж ажилласан байна.

ХОНЗҮ-ээр зорчигч гадаад иргэдийн хяналтын талаар:

Хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 54 иргэнийг бүртгэж, 53 иргэнд хасалт хийж тухайн иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.

Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар: Тайлант хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн “Саусгоби сэндс” ХХК, Чинхуа Мак нарийн сухайт ХХК-ийн БНХАУ-ын 6 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч төвд хүргүүлсэн.

1.3. Гадаадын иргэдийн хяналт шалгалтын чиглэлээр:

Тайлант хугацаанд тус газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн баталсан ӨМ-2018/02 тоот удирдамжийн хүрээнд 02 дугаар сарын 21-ний өдрөөс 03 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сум, Дундговь аймгийн Адаацаг, Айраг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Сайнцагаан сумдын нутаг дэвсгэрт хийх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Уг шалгалтын хүрээнд Дундговь аймгийн 6 аж ахуйн, нэгжийн 42 гадаадын иргэн, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэр дэх Оюутолгой ХХК-ийн уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй 11 аж ахуйн, нэгжийн болон уурхайн бүсэд 2017 оны 10 дугаар сараас хойш нэвтэрсэн нийт 1235 гадаадын иргэний мэдээллийг бүртгэл, хяналтын нэгдсэн систем ISM програмд тулгалт хийн ажиллаж байна.

1.4. Хилийн чанад болон Гадаадын иргэн, харьяатын газарт алдаатай олгогдсон, зөвшөөрөлгүй олгогдсон визийг засварласан болон хүчингүй болгосон талаар:

Тайлант хугацаанд БНХАУ-ын Хөх хотын Консулын газраас В,Ж ангиллын нэг болон олон удаагийн визийн хүчинтэй хугацааг алдаатай олгосон нийт 93 ширхэг визэнд засвар хийж 28 дугаар бүхий визийн тэмдгээр баталгаажуулан, хил нэвтрүүлсэн.

1.5. Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэдийн талаар:

Тайлант хугацаанд ГИЭЗБТХ-ийн 11 дүгээр зүйл 11.1 дэх заалтыг үндэслэн БНХАУ-ын 1 иргэн, дээрх хуулийн 22 дугаар зүйл 22.1.6, Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолын 4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн БНХАУ-ын 4, нийт 5 иргэнийг хилээр нэвтрүүлээгүй буцаасан.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

2.1. Захиргааны чиглэлээр хийсэн ажил

Байгууллагын даргын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/77 дугаар тушаалаар батлагдсан Гадаадын иргэн, харьяатын газрын “Удирдах ажилтны мэргэжил, арга зүйн цугларалт”-д газрын дарга, хяналтын улсын ахлах байцаагч,

виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, захиргааны ахлах мэргэжилтэн, ахлах нягтлан бодогч, жолооч зэрэг нийт 6 албан хаагч 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 28-ны өдрүүдэд оролцсон.

Цугларалтын үеэр шинэчлэн батлагдсан “Төрийн албаны тухай хууль” болон “Удирдах ажилтны манлайлал” сэдэвт сургалт, ахлах нягтлан бодогч нарт зориулсан санхүүгийн шинэчилсэн програмын сургалтуудад албан хаагчид тус тус хамрагдлаа.

Газрын төрийн захиргааны нийт 9 албан хаагч Өмнөд бүс дэх газрын даргатай 2018 оны үр дүнгийн гэрээг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр байгууллан ажиллалаа.

Өмнөговь аймгийн ЗДТГ-аас энэ оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан “Төрийн байгууллагуудын үйлчилгээний нэгдсэн өдөрлөг”-т оролцож, гадаадын иргэдийн виз, бүртгэл, Монгол Улсад оршин суухтай холбоотой болон иргэний харьяаллын талаар нийт 218 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажиллалаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2018 оны төлөвлөгөөний дагуу цахим орчинд мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллахад анхаарч “Мэдээллийн аюулгүй байдал” сэдэвт сургалтыг Тагнуулын ерөнхий газрын Өмнөговь аймаг дахь газрын мэргэжилтэн н.Анхбаяр 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдөр газрын нийт 10 албан хаагчид зохион байгууллаа.

2.2. Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/- 1
 - Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо- 1
 - Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо /Ерөнхий газарт/-0
 - Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
 - Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-0/
 - Ерөнхий газраас ирсэн бичиг-2
 - Ерөнхий газарт явуулсан бичиг /албан тоот-2, илтгэх хуудас-5/
 - Бусад байгууллагад хүргүүлсэн бичиг /албан тоот-9/
 - Бусад байгууллагаас ирсэн бичиг-9
 - Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-1

2.3 Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тус Газрын 03 дугаар сарын шилэн дансны мэдээллийг шивж, мэдээг Санхүүгийн хэлтэс, Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

Энэ оны 03 дугаар сард 18 албан хаагчид 14.210.024 төгрөгийн цалин олгож, татварт 612.113 төгрөг, нийгмийн даатгалд 3.699.711 төгрөгийн, хангамж бараа материалын зардалд 2.288.000 төгрөг, байр ашиглахтай холбоотой зардалд 422.413 төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 1.092.000 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн төрийн сангаар баталгаажуулан ажилласан.

2.4. Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг байнга ханган ажиллаж, газрын төв болон хариуцан ажиллаж буй аймгуудын сүлжээний дэлгэрэнгүй судалгааг гарган холбогдох хэлтэст хүргүүлж ажилласан.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР